ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 21 өдөр Дугаар А/52 Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан томилолтоор ажиллуулах журам"-ын 2.1, 3.1, 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын Сэлэнгэ аймаг дахь Төмөртэйн уурхай, Хөтөл дэх "Цемент шохойн үйлдвэр" ТӨХК, Дархан-Уул аймаг дахь "Төмөрлөгийн үйлдвэр" ТӨҮГ-ийн үйл ажиллагаатай танилцах, чиглэл өгөх ажлын хэсгийн бүрэлдэхүүний ажлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, жолооч Х.Базаррагчаа нарыг 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 06 дугаар сарын 24-ний өдрийг дуустал 3 хоногийн хугацаатай албан томилолтоор ажиллуулсугай.

2.Албан томилолтоор ажиллах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Албан томилолтын тайланг ажлын 5 өдөрт багтаан танилцуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Н.Ганболд/ -т даалгасугай.

4.Албан хаагчдын унаа, томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

132013596

ТӨБЗГ тушаал-/2023

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2023 оны 06 дүгээр сарын 21-ний
өдрийн А/52 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

СЭЛЭНГЭ, ДАРХАН-УУЛ АЙМАГТ ТОМИЛОЛТООР
АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Зорилго: Сэлэнгэ аймаг дахь Төмөртэйн уурхай, Хөтөл дэх "Цемент шохойн үйлдвэр" ТӨХК, Дархан-Уул аймаг дахь "Төмөрлөгийн үйлдвэр" ТӨҮГ-ийн үйл ажиллагаатай танилцах, чиглэл өгөх;

Хугацаа: 2023 оны 06 дугаар сарын 22-ний өдрөөс 6 дугаар сарын 24-ний өдрүүдэд;

Хаана: Сэлэнгэ аймаг дахь Төмөртэйн уурхай, Хөтөл дэх "Цемент шохойн үйлдвэр" ТӨХК, Дархан-Уул аймаг дахь "Төмөрлөгийн үйлдвэр" ТӨҮГ.

Гүйцэтгэх ажлын хуваарь:

Д/д	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Гүйцэтгэх мэргэжилтэн
1	Сэлэнгэ аймаг дахь Төмөртэйн уурхай	2023.06.22	Б.Цэнгэл жолооч Х.Базаррагчаа
2	Хөтөл дэх "Цемент шохойн үйлдвэр" ТӨХК,	2023.06.23	Б.Цэнгэл жолооч Х.Базаррагчаа
3	Дархан-Уул аймаг дахь "Төмөрлөгийн үйлдвэр" ТӨҮГ	2023.06.24	Б.Цэнгэл жолооч Х.Базаррагчаа

----- o 0 o-----

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн
А/52 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

Сэлэнгэ аймаг дахь Төмөртэйн уурхай, Хөтөл дэх "Цемент шохойн үйлдвэр" ТӨХК, Дархан-Уул аймаг дахь "Төмөрлөгийн үйлдвэр" ТӨҮГ-ийн үйл ажиллагаатай танилцах, чиглэл өгөх; Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, жолооч Х.Базаррагчаа нарын албан томилолтын зардлын төсөв.

Хугацаа: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, жолооч Х.Базаррагчаа нар нь 06 дугаар сарын 22-ны өдрөөс 06 дугаар сарын 24-ний өдрүүдэд /хуанлийн 3 хоногоор/ хийж гүйцэтгэнэ.

Д/д	Зардлын төрөл	Төсөвлөсөн /төгрөгөөр/
1	2	3
1	Байр: 2хүн х 3 хоног х 110,000 =660,000 Хоол: 2хүн х 3 хоног х 32,000 = 192,000 Унаа: 1270 км х 2390 х 0.25 х = 758,825	**1,610,825**
	Нийт дүн:	**1,610,825**

Тайлбар: Дотоод томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаалаар батлагдсан "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаалыг үндэслэв.

----- o 0 o-----